



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/699

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.2, 2023 оны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын ахмадын хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ахмад настнуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, нийгэм, соёлын үйл ажиллагаанд түлхүү оролцуулахад дэмжлэг үзүүлэн, Могод, Хангал сумдын ахмадын хороонд тус бүр 5,000,000 (таван сая) төгрөгийн тохижилтын зардлын дэмжлэг үзүүлсүгэй.

2.Сумдын Ахмадын хорооны тохижилтын зардалд шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

